

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 24 оны 07 сарын 16 өдөр

№ R-2024-33

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.6 (ii) дахь заалт болон Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2024 оны 07 дугаар сарын 08-16-ны өдрийн хооронд зохион байгуулсан цахим санал хураалтын үр дүнд дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Банк нь 2024 оны эхний хагас жилийн байдлаар 85.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 18.6%-д хүргэж ажилласан болохыг;
- Банкны Дүрэмд зааснаар ногдол ашиг хуваарилах асуудал нь стратегийн асуудал болохыг;
- Банкны гүйцэтгэх удирдлага нь Банкны 2024 оны эхний хагас жилийн ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах ("Хагас жилийн ногдол ашиг")-ыг ТУЗ-д санал болгосныг; мөн
- ТУЗ нь Банкны Дүрмийн 8.6 (ii) дахь заалтын дагуу дор дурдсан дүнгээр Хагас жилийн ногдол ашгийг зарлан хуваарилах шийдвэр гаргуулахаар хувьцаа эзэмшигчдэд санал болгож буйг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсан тохиолдолд, Хагас жилийн ногдол ашигт нийт 18,948,600,000.00 (арван найман тэрбум есөн зуун дөчин найман сая зургаан зуун мянга) төгрөг буюу нэгж хувьцаанд 18.00 (арван найм) төгрөг зарлан хуваарилахыг дэмжсүгэй.
- Хувьцаа эзэмшигчид ногдол ашиг зарлан хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд, хагас жилийн ногдол ашиг хуваарилах асуудлыг шийдвэрлэх Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("ХЭЭБХ")-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болох 2024 оны 8 дугаар сарын 08-ны өдрийг тухайн хурал зохион байгуулагдах хэлбэрээс үл хамааран, Хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
- Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойших 7 хоногоос хэтрүүлэлгүйгээр ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлсүгэй. Хувьцаа эзэмшигч нь холбогдох хууль тогтоомжийн дагуу банкны тодорхой дансаар

дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

A black ink handwritten signature, appearing to be "Н.Мөнхцэлмэг".

Н.МӨНХЦЭЛМЭГ